



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 467

Улаанбаатар хот

Нэр бүхий арилжааны банкуудын  
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.7, 63.1.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 03 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 365, 388 дугаар тогтоолоор тус тус олгогдсон дараах нэр бүхий арилжааны банкуудын “үнэт цаасны зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавараар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хүчингүйд тооцсугай.


- 1/ “Улаанбаатар хотын банк” ХХК
- 2/ “Худалдаа хөгжлийн банк” ХХК
- 3/ “Чингис хаан банк” ХХК
- 4/ “Хаан банк” ХХК
- 5/ “Голомт банк” ХХК
- 6/ “Төрийн банк” ХХК
- 7/ “Капитрон банк” ХХК
- 8/ “Капитал банк” ХХК
- 9/ “Хас банк” ХХК
- 10/ “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Монголбанкаар арилжаалагдаж буй Засгийн газрын өрийн хэрэгслийг худалдан авах захиалгыг бусад (шууд бус оролцогч)-аас хүлээн авахгүй байхыг дээрх нэр бүхий арилжааны банкуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, “Засгийн газрын үнэт цаас гаргах арилжаалах журам” болон “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-д холбогдох өөрчлөлтийг тус тус оруулахыг Хорооны дарга Д.Баярсайханд зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН